



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Аймгийн Мал эмнэлгийн газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ДГА-2022/153/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Сайншанд сум 2022 он	Дарга, тэргүүлэх аудитор: Т.Ган-Өлзий Утас: 70522734 Цахим хаяг: gan-ulziit@audit.gov.mn Аудитын менежер: У.Оюунтүлхүүр Утас: 70523020 Цахим хаяг: oyuntulkhuur.u@audit.gov.mn Аудитор: Л.Равдандорж Утас: 70523020 Цахим хаяг: ravdandorjl@audit.gov.mn
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу



**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

44103 Дорноговь аймаг, Сайншанд сум,
3 дугаар баг, Орон нутгийн өмчийн III байр,
Утас: (705) 2-27-34

Вэб сайт: dornogovi@audit.gov.mn

2021.07.24 № 1-6/98
танай _____-ны № _____-т

МАЛ ЭМНЭЛГИЙН ГАЗРЫН ДАРГЫН,
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
У.МӨНГӨНХҮҮ ТАНАА

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Мал эмнэлгийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Мал эмнэлгийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгадагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.ГАН-ӨЛЗИЙ

Нэг. Санхүүгийн ба төсвийн гүйцэтгэлийн тайлангийн гол үзүүлэлтүүд

		/сая төгрөгөөр/	
	Үзүүлэлт	2020.12.31	2021.12.31
Санхүүгийн байдлын тайлан			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	429.8	286.3
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	859.4	759.6
	Нийт хөрөнгийн дүн	1,289.3	1,045.9
	Нийт өр төлбөрийн дүн	13.5	10.1
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,275.8	1,035.7
	Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,289.3	1,045.9
Санхүүгийн үр дүнгийн тайлан			
	Үйл ажиллагааны орлогын дүн	3,032.4	2,895.7
	Үйл ажиллагааны зардлын дүн	3,822.8	3,134.4
	Үйл ажиллагааны үр дүн	-790.4	-238.7
	Үйл ажиллагааны бус үр дүн	0.1	1.3
	Үйл ажиллагааны нийт үр дүн	-790.5	-240.0
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан			
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,066.2	1,275.8
	Тайлант оны үр дүн	-790.5	-240.0
	Эцсийн үлдэгдэл	1,275.8	1,035.7
Мөнгөн гүйлгээний тайлан			
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	1,159.2	1,654.4
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	1,144.0	1,649.8
	Үйл ажиллагааны ЦМГ	15.2	4.6
	Хөрөнгө оруулалтын ЦМГ	15.2	4.6
	Санхүүгийн ажиллагааны ЦМГ		
	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	0.0	0.0
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		
Төсвийн гүйцэтгэлийн тайлан			
	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	492.4	614.4
	Урсгал зардал	492.4	614.4
	Хөрөнгийн зардал		
	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр		
	Улсын төсвөөс санхүүжих	490.3	825.6
	Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	2.1	2.2

Хоёр. Байгууллага, түүний үйл ажиллагаа

Зорилго: Мал амьтны эрүүл мэндийг хамгаалах, мал амьтны гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлагыг хангуулах, нийтийн эрүүл мэндийг хамгаалах.

Аймгийн Мал эмнэлгийн газар нь дараах чиг үүргийг хэрэгжүүлдэг. Үүнд:

1. Мал, амьтны өвчнөөс урьдчилан сэргийлэх, тэмцэх.
2. Мал, амьтны гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний эрүүл, аюулгүй байдлыг баталгаажуулах.
3. Аймгийн хэмжээний мал эмнэлгийн төр, хувийн хэвшлийн байгууллагыг нэгдсэн бодлогоор ханган нийтийн эрүүл мэндийг хамгаалах.

Гурав. Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Санхүүгийн тайлангийн аудитаар онцлон асуудал илрээгүй болно.

Дөрөв. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

Тайлант хугацаанд оруулбал зохих 149 мэдээллээс хугацаандаа оруулсан 144 мэдээлэл, хугацаа хоцроосон 2, хугацаа болоогүй 3 мэдээлэл байна. Шилэн дансны мэдээллийн цахим сайтад байршуулсан мэдээллүүд нь үнэн зөв алдаагүй байна.

Тав. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Өмч хамгаалах комиссын үйл ажиллагааг авч үзэх.

Зургаа. Аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 105.1 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 104.4 сая төгрөгийн алдааг залруулж, 0.4 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 0.3 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж өгсөн.

6.1 Залруулсан алдаа

1. Орон нутгийн орлого болон төсөв захирагч хоорондын шилжүүлэг дансаар нийт 2.8 сая төгрөгийг ангилал зөрүүлэн тайлагнасан байна.
2. Орон нутгийн дэмжлэгээр худалдан авдаг вакцины үлдэгдэл төлбөрийг Мал эмнэлгийн ерөнхий газарт төвлөрүүлж авлага, өглөг бүртгээгүй нийт 19.1 сая төгрөгийн зөрчил үүсгэсэн байна.
3. Төсвийн гүйцэтгэлийн тайлангийн санхүүжилтийн дүнг 30.2 сая төгрөгөөр дутуу тайлагнасан байна.
4. Үндсэн болон нэмэлт дансны орлогын эх үүсвэрийн дүнг 0.8 сая төгрөгөөр зөрүүлэн тайлагнасан байна.
5. Мөнгөн гүйлгээний тайланд 4.6 сая төгрөгийн биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардлын дүнг тайлагнаагүй байна.
6. Ажлаас чөлөөлөгдсөн албан хаагчийн ажилласан хугацааны ээлжийн амралтын тооцоог суутгаж үйл ажиллагааны орлогоор хүлээн авсан байна.
7. Цалингийн урьдчилгаа болон нэг удаагийн шагнал урамшууллаар олгосон нийт 46.4 сая төгрөгийг тооцооны дансаар дамжуулаагүй шууд зардалд бүртгэсэн байна.

6.2 Төлбөрийн акт

Хүчин төгөлдөр бус засвартай, баталгаажуулаагүй томилолтын хуудсыг үндэслэж 4 албан хаагчид нийт 0.4 сая төгрөгийн томилолт олгосон байна.

6.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Санхүүгийн үйл ажиллагаатай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт: Байгууллагын жилийн эцсийн эд хөрөнгийн тооллогыг хийхдээ эд хариуцагч болон тооллогын комиссын гишүүдээр гарын үсэг зуруулж баталгаажуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-т “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, 13.5-д “анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно”, 13.7-д “анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

1.2. Өгсөн зөвлөмж: Байгууллагын эд хөрөнгийг эзэмшиж, ашиглаж байгаа эд хариуцагч бүрээр тоолж баталгаажуулан данс бүртгэлд тусгаж байх

2. Орлоготой холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт: Тарилгын үйлчилгээний хөлсөнд илүү шилжүүлсэн 0.3 сая төгрөгийн буцаалтыг үйл ажиллагааны орлогоор хүлээн авч данс бүртгэлд тусгасан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.9-т “төсвийн орлого” гэж хууль тогтоомжийн дагуу улсын болон орон нутгийн төсөв бүрдүүлэх орлого, төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг, 22 дугаар зүйл 22.5-д “Төсвийн ангиллын зүйлд санаатайгаар буруу мэдээлэл оруулж төсвийн орлого, зарлагын хэмжээг өөрчлөхийг хориглоно”, Сангийн сайдын 2019 оны 74 дүгээр тушаалаар батлагдсан “Төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах, тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгах, хяналт тавих журам”-ыг тус тус зөрчсөн байна.

2.2. Өгсөн зөвлөмж: Холбогдох хууль, тогтоомжид заасан хэм хэмжээг баримтлан Төсвөөс гарсан зардал, залруулгын гүйлгээг орлогоор хүлээн зөвшөөрөхгүй байх, холбогдох данс бүртгэлд цэвэрлэх бичилтийг хийж бодит гүйцэтгэлээр үнэн зөв тайлагнаж байх.

7.1 Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн мэдээлэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1			1			
	НИЙТ	1	1			1			

7.2 Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл:

/сая төгрөгөөр/

№	Төсвийн захирагчийн ангилал	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
A	1	2	3	4	5	6	7	8	9	10	11
1	Аймгийн Мал эмнэлгийн газар	10	105.1	7	104.4	1	0.4	-	-	2	0.3
	НИЙТ	10	105.1	7	104.4	1	0.4	-	-	2	0.3